

Базылханы Напил^{1✉}, Алтангэрэлийн Энхтөр², Рэнцэндожийн Төрбат³

¹Олон Улсын Түрэг Академи.

Казахстан улс, Астана хот, Дипломат хотхон, 179-р гудамж

²Шинжлэх Ухааны Академийн Археологийн хүрээлэн.

Монгол улс, Улаанбаатар-13330, Энхтайваны өргөн чөлөө,

Шинжлэх Ухааны Академийн хүрээлэнгүүдийн нэгдсэн I байр

³Монгол Улсын Боловсролын их сургууль.

Монгол улс, Улаанбаатар-48, Бага-тойруу-14, МУБИС-ийн 6-р байр

Улаан чулуутын эртний түрэг бичээсийн угсаатан-соёлын утга зүйн тухайд

Хураангуй. Улаан чулуутын өвөлжөөний бичээс болон тамгануудыг дахин нягтлан, шинээр хуулбар хэв, гэрэл зураг болон гар зургийг нь авч судалсан болно. Учир нь уг бичээсийн агуулгыг өмнөх судлаачид мани шашинтай шууд холбогдуулж ирсэн юм. Иймд тухайн бичээсийг газар дээр нь дахин нягтлан унших, харьцуулан судлах шаардлагатай болсон юм. Ер өрнөдийн судлаачид эртний түрэг, уйгурын үеийн хадны бараг ихэнх бичээсийг мани шашинтай холбож ирсэн уламжлалтай байдаг. Судалгааны ажлын явцад эртний түрэгийн үеийн болон уйгурын үеийн үсэг бичгийн тиг журмыг болон тамга тэмдгийг харьцуулан үзсэн бөгөөд мани шашны ул мөр гэхээр ямарваа нэгэн баримт болон үр дүр гаргах үндэслэл тун бага гэж үзнэ. Тэнгэр, Газар-дэлхийн ойлголт нь ерөөсөө нүүдэлчдийн амин гол баримтлал, тухайлбал энэхүү «Улаан чулуут» хадны бичээс болон тамганууд нь газар нутаг, хадан газартаа тайллага үйлдсэн жирийн нэгэн үйлдэл болох нь бичээсийн агуулгаас илт харагдаж байна. Улаан чулуутын өвөлжөөний эртний түрэг (руни) бичиг болон тамгад нь эртний түрэгийн үе буюу VII-VIII зууны үед холбогдоно. Тухайн газар дахь 4 хэсэг бичээсийн утга агуулга нь ч нүүдэлчдийн угсаатан-соёлын утга зүйн үүднээс ажиглаваас, уйгурын үеийн мани шашинтай огт хамааралгүй болно. Тиймээс ч, Улаан чулуутын 4 бичээст нийт -11 тамга байгаа нь тус хадтай ууланд хуран цугларсан 4 зүгийн 9 овог аймаг оролцон хадны шүтлэг хийсэн, хадандаа тайллага тахилын зан үйл үйлдсэн, хутаг өлзий хүсэж залбирсан онцгой газар нутаг болох нь тодорхой байна.

Түлхүүр үг: Эртний түрэгийн үе, Улаан чулуут, хадны бичээс, тамга, хадны шүтлэг, угсаатан-соёлын утга зүй, дахин нягтлах асуудал

Napil Bazilkhan^{1✉}, Enkhtur Altangerel², Turbat Rentsendorj³

¹International Turkic Academy,

Street E-1798, Diplomatic Town, Astana, Republic of Kazakhstan

²Institute of Archaeology,

Mongolian Academy of Sciences Building-1,

Peace avenue, Ulaanbaatar 13330, Mongolia

³Mongolian National University of Education.

6th, Baga-toiruu-14, Ulaanbaatar-48, Mongolia

On the Ethno-Cultural Semantics of the Ancient Turkic Inscriptions of Ulaan Chuluut

Abstract. The ancient Turkic inscriptions and tamgas at Ulaan Chuluut appear to date to the Ancient Turkic period, namely the 7th–8th centuries. From the ethnocultural-semantic perspective, the content of the four inscriptions mentioned shows no relation whatsoever to the Manichaean religion of the Uyghur period. Consequently, the presence of a total of 11 tamgas on these four inscriptions indicates that this rocky mountain was a special sacred site where representatives of 9 clans and tribes from the four directions gathered, performed stone-worship rituals, made offerings and sacrifices upon the rocks, and prayed for blessings and good fortune.

Keywords: Ulaan Chuluut, ancient Turkic inscriptions, tamga, stone worship, ethnocultural semantics

Удиртгал

Төв аймгийн Лүн сумын Өгөөмөр багийн Улаан чулуут хэмээх өвөлжөөний арын эгц хаднаа сийлэгдсэн эртний түрэгийн үед холбогдох бичээс болон тамгануудтай газрыг анхлан 2016 онд Р.Төрбат олж илрүүлсэн бөгөөд Я.Цэрэндагва, Р.Төрбат, С.Далантай нар баримтжуулалт хийн «Улаан чулуутын өвөлжөөний хадны зураг, бичээсийн дурсгал» хэмээн хэвлүүлсэн байна. (Tserendagva, Turbat, 2017: 65-80). 2017 онд Ю.Болдбаатар, Ц.Цэрэндагва, Ц.Төрбат нар «Улаан чулуутын нэгдүгээр руни бичээс» хэмээн нэрлэсэн хамгийн том дөрвөн мөр бичээсийг нь тайлан уншжээ (Boldbaatar, Tserendagva, Turbat, 2017: 239-244). Мөн онд Ц.Баттулга нягтлан судлан улмаар 2019 онд Б.Аззаяа, И.В. Кормушин нарын хамт орос хэлээр өгүүлэл хэвлүүлжээ (Battulga, Azzaya, Kormushin, 2019: 57-65). Уг бичээсийн талаар Ц.Баттулга 2020 онд «Улаан чулуутын IV бичээс» (Ц.Баттулга, 2020: 295), (Ц.Баттулга, 2022А: 210, 212-213), 2022 онд «Улаан чулуутын бичээс» хэмээн дөрвөн бичээсийг өөрөөр дугаарлан уншиж дахин хэвлүүлжээ (Ц.Баттулга, 2022Б: 219-225). Мөн 2022 онд Р.Төрбат «Лүнгийн хадны зураг» гэдэг судалгааны номдоо «Улаан чулуутын нэгдүгээр бичээс» (Turbat, 2022: 114, 115-117) болон, тамгануудын тодорхойлолт, харьцуулсан баримтуудаа хэвлүүлжээ (Turbat, 2022: 157).

2021 онд Нурдин Усеев уг бичээснүүдийг дахин нягтлан уншиж «Монгол улс дахь Улаан чулуут бичээсүүд ба эртний түрэгүүдийн эгц хадны тухай ойлголт» хэмээх өгүүлэл хэвлүүлжээ (N.Useev, 2021: 101-112).

Бид 2024 онд уг бичээсийн цаасан дардсанд хэвийг авч, тамгануудыг дахин нягтлан, угсаатан-соёлын утга зүйн тухай өөрсдийн судалгааны үр дүнг нийтэлж байна.

Судалгааны арга зүй

Эртний түрэг бичигт хадны бичээсийг дахин нягтлан унших, бичээстэй хамт буй тамга тэмдгийг дахин хянан баримтжуулах, тамга судлалын харьцуулсан арга, эртний түрэг, уйгурын үеийн үсэг бичгийн тэг тэмдгийг харьцуулсан арга болон хээрийн хайгуулын аргазүйг ашигласан болно. Мөн нүүдэлчдийн шүтлэг бишрэл болон мани шашны баримтлалтай харьцуулан шинжиж үзсэн болно.

Хэлэлцүүлэг

Уг хадны бичээс тамгануудыг Ю.Болдбаатар, Ц.Цэрэндагва, Р.Төрбат нар «VIII-IX зууны



Түрэг, Уйгурын үед холбогдох Орхоны руни бичгийн дурсгал байна... Гурвалжин уул, Енисейн Кара-Юс (E-39) дурсгалын утга агуулгатай адил байна. Бичээсийг бичсэн Билгэ чур ...хаант төрөөс өөрт эзэмшүүлсэн нутгийн дээсийг эсвэл өөрийн өвөлжөөгөө баталгаажуулж тэмдэглэсэн байх аль нь боловч газрыг шүтэх шүтлэг, газрын эзэнд (савдагт) хандаж буй хандлагаараа «өөрийн газрын эзэн савдагт даатган баталгаажуулж буй зан үйл болох нь илэрхий байна. Энд бас согдуудаар тээгдэн ирсэн Манихейн шашны хос үүтэлт үзлийн (dualism) нэг бүтээгч нь газар дэлхий хэмээн үзэх үзлийн нөлөө зохих хэмжээгээр туссан байна...» гэж дүгнэжээ (Boldbaatar, Tserendagva, Turbat, 2017: 241).

Ц.Баттулга, Б.Аззаяа, И.В. Кормушин нар «... энэхүү бичээс нь IX зууны үеийн мани шашинтай холбоотой (*qutluγ bolij-өлзий хутагтай болтугай*), Ар ханан, Тавьтын бичээстэй төстэй, дайнд мордогсдыг ерөөсөн (*озмыш йарган йорты - озмыш ярган зорчив*), мөн нас барсан цэргийн тэргүүн нарт тайллага хийсэн» утга агуулгатай гэж тайлбарлажээ (Battulga, Azzaya, Kormushin, 2019: 64).

Бид бичээсүүдийг уншихдаа өөрсдийн судалгааны эх хэрэглэгдэхүүн дээр тулгуурлан сийрүүлэв. Үүнд:

1-р бичээс:	[Oz]miš Yaryan yurti	Озмыш Йарган+ы нутаг нь (болай)
2-р бичээс:	Bekčil Abičaya yurti Qutluγ bo[lug]	Бекчил Абычага+гийн нутаг нь (болай), хутаг болсугай!
3-р бичээс:	Qaya Čač Yaš Qaγ Uγuru qutadmiš	Хая Чач Йаш Хан, Өлзий хутаг+тай болжухуй.
4-р бичээс:	Qaya uluγi yalim qay[a]	Хадны их (сүрлэг) нь эгц хад.
	Beγlig Čur	Бенлиг Чур
	bitidim	бичлээ (би).
	Qaya Čur yerde uluγi yalim qaya ermiš	Хая Чур газарт их (сүрлэг) нь эгц хад ажухуй.

Бид шинээр үйлдсэн цаасан дардсанд хэв болон гэрэл зураг, гар зургуудынхаа үндсэн дээр бэлдсэн бичээсийн эртний түрэг бичгийн тамга-үсгийн тиг зураглалыг болон тухайн бичээс бүрд хамт сийлсэн маш тод тамгануудыг толилуулбаас, ийм байдалтай байгаа болно. Үүнд:

	
1-р бичээс, 3 тамгатай	2-р бичээс, 3 тамгатай
	
3-р бичээс, 3 тамгатай	4-р бичээс, 2 тамгатай

Учир иймд, энэхүү 4 бичээсийг «Улаан чулуут» хэмээх энэхүү хурц шовх, эгц хадтай уулын өмнө зүгийн доод бэлийнхэн, уулын хаяаны хаданд өөрөөр хэлбэл, хадны толигор талд бие-биеэс холхон зайтайгаар, 4 төлөөлөгчийн тус тусынх үг хэллэгийг, мөн тус бүрийнх нь тамгануудын хамтаар сийлж бичсэн гэмээр байна. Харин эртний түрэг бичгийн үсэг буюу тамга-үсгийн тиг зураглалын ижил төстэй байдлыг харвал, тухайн үед нэгэн **bitigči** > бичээч л тусгайлан сийлсэн болох нь ажиглагдана.

Эртний түрэг бичгийн үсэг буюу тамга-үсгийн тиг зураглалын ерөнхий байдал басхүү «Эшир» (Ашына) хаадын тамга байгаа нь эртний түрэгийн үе буюу VII-VIII зуунтай холбоотой болов уу хэмээн үзэж байна.

Нүүдэлчдийн хадны шүтлэг. Эртний түрэг хэлний **qaya** > хайа «хад, хад чулуу, уул хад», монгол бичгийн хэлний **qada** > хад «хад, хад чулуу, ургаа чулуу, уул хад» нэгэн үг байдаг билээ.

Нүүдэлчид хадтай газрыг ихэд бэлгэшээн, өөрсдөө ч тухай хадтай уул, хад чулуугаар хил

хязгаараа тогтоон тэмдэглэж, шүтэж ирсэн агаад, хутаг өлзийтэй өнтэй, ан гөрөөтэй жаргалтай сайхан байхыг хүсэж, улмаар тахилга тайллагын зан үйлийг үйлдэж иржээ. Монголчуудын уул овооны тахилгын уг гарал нь ч үүнтэй шууд түүхэн жамын холбоотой болай.

Жишээлбэл, Енисей мөрний Кара-Юс-1 (Е-39) **beṅkü qaya** // **meṅkü qaya** - «мөнхийн хад», Өвөрхангай аймгийн Тавьтын хадны бичээс **yalim qaya** «эгц хад», Говь-Алтай аймгийн Бигэр-6 бичээс **yalim** - «эгц», Булган аймгийн Ар ханангийн бичээс **qayaqī edgü bolzun** - «хадан нь ашид, үргэлжид болсугай», Bitiç bitidim: **qaya Teṅiriken:qutluγ boluγ** - «Битич бичлээ би, хад нь Тэнгэрлэг хутагтай болсугай, Хангидай-2 бичээс **[ya]lim qayaqa (bitidim)** – “эгц хаданд бичлээ би” гэх зэрэг тохиолдож байгаа нь эртний нүүдэлчдийн хадны шүтлэг, бишрэлтэй нягт холбоотой хэмээн үзэж байна.

Эдүгээгийн монгол хэлнээ «хад сайтын үнэг бардам, хадам сайтын хүргэн бардам», «хадан гэрт ойртох /гарах/, «хадан гэртээ очих/харих/», «хад мөргөх», «хадны мангаа» (Монгол хэлний их

тайлбар толь) зэрэг үг, хэлц нь эртний угсаатан-соёлын энэхүү хадны шүтлэгтэй холбоотой, шууд улбаатай гэж хэлж болно.

Харин, урьд өмнөхийн судлаачид «*йорты-зорчив*» хэмээн ташаа уншсан уг үг болбоос, Баянхонгор аймгийн Замын бууц (Улаан цохиот) бичээст: **Ediziṅ: yurti: ediz atṅ eki: yurti** - Эдизийн нутаг нь, эдиз нэрт хоёр нутаг нь, Говь-Алтай аймгийн Алтан хадны бичээст: **El bitigniṅ tudunī yurti Ečük qut+luy boluṅ** - Эл битигч (бичээч) тудуны нутаг нь, Эчүк хутагтай болсугай, мөн Бичигтийн бууц буюу Бигэр - 3 бичээст: **Külüg anī: yurti** - Хүлэг баатар түүний нутаг нь, Давиртийн бууцны бичээст: **Alp Uruṅ: yurti: qutluy boluṅ** - Агуу Урунгу нутаг нь, хутагтай болсугай, **Uluṅ qaya** - Агуу их (сүрлэг) хад зэрэг утгатай тохиолдож байгаа болно.

Yurti - хэмээсэн үг нь эртний түрэг бичгийн хэлнээ «1. Гэр, эзэмшил газар, нутаг ус, газар нутаг, 2. Гэрийн бууц, буурь, гэрийн ором» зэрэг утгыг илэрхийлдэг байна.

Харин, **yor-** > йор - язгуурт үйл үг болбоос

«зорих, явах, хүрэх, зорчих» гэсэн утгатай агаад энэхүү уор - > йор - язгуурт үйл үгэнд «+tī» өнгөрсөн цагийн 3-р биеийн нөхцөл залгаваас **yortī** - «зорив, зорчив, хүрэв, хүрэлцэн ирсэн» гэсэн утга санаатай болдог байна.


Энд бас нэмэн хэлэхэд, нүүдэлчдийн хадны болон агуйн оршуулгын зан үйл байдгийг археологийн олдворууд бэлхнээ баталж байна. Монгол улсын нутагт одоогоор 70 гаруй газарт 100 орчим хадны оршуулга газарт малтлага судалгаа хийсэн байгааг дурдах хэрэгтэй байна (Erdenebat, 2014: 304).

Учир иймд хадны шүтлэг болон хадны оршуулга өөр хоорондоо түүхэн нарийн холбоотой болох нь илхэн гэж хэлж болно.

Улаан чулуутын тамганууд: Тус хаднаа 20 гаруй овог аймгийн тамга сийлсэн байна. Үүнд бидний судалгаагаар Улаан чулуутын 4 бичээс дээрх 9 овгийн тамгыг бусад газрын тамгануудтай урьдчилсан байдлаар харьцуулан үзвэл:

№	Улаан чулуутын 4 бичээс дээрх тамганы гар зураг	Монгол нутаг дахь бусад дурсгалд тохиолдох ижил төстэй тамганууд
1.	 3-р бичээс	 Кутлук хаан,  Билгэ хаан, Күлтэгин
2.	 3-р бичээс	 Дунд мандал  Бичигт улаан хад
3.	 3-р бичээс, 4-р бичээс	 Бичигт улаан хад, Дарви
4.	 4-р бичээс	 Шаахар
5.	 1-р бичээс	 Гурван мандал,  Шивээт улаан  Бөмбөгөр
6.	 1-р бичээс	 Шаахар  Дунд мандал

7.	 1-р бичээс	 Шивээт улаан  Шивээт улаан, Манхан
8.	 2-р бичээс	 Бичигт улаан хад
9.	 2-р бичээс	 Бөмбөгөр  Дэл уул

		
Элстэй давааны хад чулуун дээрх тамганууд		

Улаан чулуутын өвөлжөөний болон Элстэй давааны, Мааньтын өврийн тамгануудыг цаашид улам нягтлан харьцуулан судлах шаардлагатай бөгөөд энэ нь нүүдэлчдийн тамга судлалд бас нэгэн шинэ түүхэн мэдээ болж эх сурвалжуудыг баяжуулах болно.

Дүгнэлт

Улаан чулуутын бичээс болон тамганууд нь эртний түрэгийн үе буюу VII-VIII зуунтай холбоотой бололтой байна. Эртний түрэг, уйгурын үеийн хадны энэ мэт богинохон бичээснүүдийг өрнөдийн судлаачид ялангуяа И.Л.Кызласов (Кызласов, 1998: 34-35), И.В. Кормушин зэрэг бичээс судлаачид мани шашинтай шууд л холбогдуулж ирсэн байдаг.

Судалгааны ажлын явцад эртний түрэгийн үеийн болон уйгурын үеийн үсэг бичгийн тэг журмыг болон тамга тэмдгийг харьцуулан үзсэн бөгөөд мани шашны ул мөр гэхээр ямарваа нэгэн баримт болон үр дүр гаргах үндэслэл тун бага гэж үзнэ. Тэнгэр, Газар-дэлхийн ойлголт нь ерөөсөө нүүдэлчдийн амин гол баримтлал, тухайлбал энэхүү «Улаан чулуут» хадны бичээс болон тамганууд нь газар нутаг, хадан газартаа тайллага

үйлдсэн жирийн нэгэн үйлдэл болох нь бичээсийн агуулгаас илт харагдаж байна.

Дурдсан 4 бичээсийн утга агуулга нь ч нүүдэлчдийн угсаатан-соёлын утга зүйн үүднээс ажиглаваас, уйгурын үеийн мани шашинтай огт хамааралгүй болно.

Тиймээс хадны бичээст «хаданд нэр алдраа үлдээх нь нэр төр, алдар гавьяаны хэрэг» огтоос биш, харин ч уул хадаа, онцгой эгц хадаа, хадтай байгаль дэлхийгээ тахин шүтэж хайрлан яваа нүүдэлчдийн хадны шүтлэгтэй холбоотой, «хадны мангаатай» буюу хадны оршуулгын зан үйлтэй холбогдох учиртай нарийн мэдрэмжийн тод илрэл гэмээр байгаа юм.

Тиймээс ч, Улаан чулуутын 4 бичээст нийт - 11 тамга (давхардсан 3) байгаа нь тус хадтай ууланд хуран цугларсан 4 зүгийн 9 овог аймгийн хадны шүтлэг хийсэн, хадандаа тайллага тахилын зан үйл үйлдсэн, хутаг өлзий хүсэж залбирсан онцгой газар нутаг болох нь тодорхой байна.

Чинагшид, Улаан чулуутын орчимд хээрийн малтлагын болон хайгуулын судалгааг өргөн хэмжээгээр гүйцэтгэх шаардлагатай болно.

НОМ ЗҮЙ

Баттулга, Ц. *Монголын руни бичгийн бага дурсгал*. Монголын археологийн өв. XII боть. Улаанбаатар, 2020.

Баттулга, Ц. *Монголын руни бичгийн бага дурсгал*. Монголын археологийн сонгомол өв. III боть. Улаанбаатар, 2022.

Баттулга, Ц. *Монголын руни бичгийн дурсгалын шинэ судалгаа. Монголын төв, умард бүс нутаг дахь руни бичгийн дурсгал*. II. Улаанбаатар, 2022.

Баттулга, Ц., Азаяа, Б., Кормушин, И.В. “О новом типе памятных текстов из числа «малых» наскальных рунических надписей Монголии.” Тюрко-монгольский мир: история и культура. Материалы международной научной конференции, посвященной 90-летию со дня рождения С.Г. Кляшторного. 2019: 57-65.

Болдбаатар, Ю., Цэрэндагва, Я., Төрбат, Р. “Улаан чулуутын нэгдүгээр руни бичээс.” *Археологийн судлал*. Tomus XXXVI, 2017: 239-244.

Төрбат, Р. *Лүнгийн давааны хадны зураг*. Улаанбаатар, 2022.

Цэрэндагва, Я., Төрбат, Р. “Улаанчулуутын өвөлжөөний хадны зураг, бичээсийн дурсгал.” *Археологийн судлал*. Tomus XXXVI, 2017: 65-80.

Эрдэнэбат У. “Дундад зууны нүүдэлчдийн хадны оршуулгын соёл.” *Талын морьтон дайчдын өв соёл. VII-XIV зууны Монголын хадны оршуулгын шилмэл хэрэглэгдэхүүн*. 2014: 304.

Кызласов, Л.Р. Северное Манихейство и его роль в культурном развитии народов Сибири и Центральной Азии. *Вестник Московского Университета*. Сер. 8, История № 3, 1998: 8-35.

Useev, N. *Moğolistandaki Ulan Çuluut Yazıtları ve Eski Türklerde Yalım Kaya Kavramı, Orhon Yazıtları ve Türk - Moğol İlişkileri* (YAYINA HAZIRLAYAN: İlhan Şahin, Enkhbat Avirmed, Güljanat Kurmangalieva Ercilasun). Istanbul, 2021.

REFERENCES

Battulga, Ts. *Mongolyn runi bichgiin бага дурсгал*. Mongoliin arkheologiin өв. XII boti. Ulaanbaatar, 2020.

Battulga, Ts. *Mongolyn runi bichgiin бага дурсгал*. Mongolyn arkheologiin songomol өв. III boti. Ulaanbaatar, 2020.

Battulga, Ts. *Mongolyn runi bichgiin dursgalyn shine sudalgaa. Mongolyn töv, umard büs nutag dakhi runi bichgiin dursgal*. II. Ulaanbaatar, 2022.

Battulga, Ts., Azazya, B., Kormushin, I.V. “On the new type of memorial texts among the so called ‘minor’ runic inscriptions of Mongolia.” *The Turkic-Mongolian World: History and Culture. Proceedings of the International Scientific Conference dedicated to the 90th anniversary of the birth of S. G. Klyashtorny*. 2019: 57–65.

Boldbaatar, Yu., Tserendagva, Ya., Turbat, R. “The first runic inscription of Ulaan Chuuluut.” *Arkheologiin Sudlal*. Vol. XXXVI: 239–244.

Turbat, R. *Rock carvings of the Lun Mountain*. Ulaanbaatar, 2022.

Tserendagva, Ya., Turbat, R. “Rock carvings and inscriptions of Ulaan Chuuluut.” *Arkheologiin Sudlal*. Vol. XXXVI, 2017: 65–80.

Erdenebat, U., “Dundad zuuny nüüdelchdiin khadny orshuulgyn soyol”. *Talyn moriton daichdyn öv soyol. VII-XIV zuuny Mongolyn khadny orshuulgyn shilmel khereglegdekhüün*. 2014: 304.

Kyzlasov, L.R. Northern Manichaeism and its Role in the Cultural Development of the Peoples of Siberia and Central Asia. *Bulletin of Moscow University*. 8, № 3, 1998: 8-35.

Useev, N. *Moğolistandaki Ulan Çuluut Yazıtları ve Eski Türklerde Yalım Kaya Kavramı, Orhon Yazıtları ve Türk - Moğol İlişkileri* (YAYINA HAZIRLAYAN: İlhan Şahin, Enkhbat Avirmed, Güljanat Kurmangalieva Ercilasun). Istanbul, 2021.



Open Access This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, adapt, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial.

See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>